

999

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА,
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2010 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 152/396

Улаанбаатар хот

Гадаадад сургалтын төрийн сангийн
зээлээр суралцуулах зарим арга
хэмжээний тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.14, 1.2.15 дугаар заалтыг үндэслэн, Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийг баримтлан ТУШААХ нь:

1.Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр Өндөр хөгжилтэй орны их сургуулийн бакалавр, магистрантурт аймаг бүрээс нэг иргэнийг суралцуулахаар сонгон шалгаруулах ажлыг 2010 оны 9 дүгээр сарын 27-ны дотор зохион байгуулахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлагын хэлтсийн дарга Д.Нямжавт даалгасугай.

2.Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнийг 2010 оны 10 дугаар сарын 1-нээс англи хэлний 3 сарын эрчимжсэн сургалтад хамруулан тэдгээрийг Өндөр хөгжилтэй орны их сургуулийн бакалавр, магистрантурт суралцах бэлтгэлийг хангуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Мэргэжлийн боловсролын газрын дарга М.Баасанжавт даалгасугай.

3.Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн болон дотоодын хэлний бэлтгэлийн сургалтын төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА
Ч.ХҮРЭЛБААТАР



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД
Ё.ОТГОНБЯАР